



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/9/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: [orkhon@audit.gov.mn](mailto:orkhon@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: [www.dalaivanaudit.mn](http://www.dalaivanaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар



## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3.Аудитын тайлан .....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Залруулсан алдаа .....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
Аудитын зөвлөмж .....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал .....	17

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМГИЙН САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГА Д.САЙЗМАА ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,037,070.00</b>	<b>5,573,870.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,023,500.00	2,212,500.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	4,023,500.00	2,212,500.00
31130	Нэмэлт санхүүжилт	4,023,500.00	2,212,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,013,570.00	3,361,370.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,798,070.00	3,305,370.00
35110	Тусгай зориулалттай материал	3,798,070.00	3,305,370.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	215,500.00	56,000.00
35410	Бичиг хэргийн материал	215,500.00	56,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,616,070.60</b>	<b>20,388,884.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	18,616,070.60	20,388,884.91
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	18,563,570.60	20,388,884.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,666,666.68)	(5,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,558,874.00	36,844,574.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,577,415.86)	(27,348,019.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,695,736.00	21,435,736.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,446,956.86)	(10,543,406.03)
39301	Программ хангамж	680,000.00	680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(680,000.00)	(680,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	420,000.00	420,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(367,500.00)	(420,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>26,653,140.60</b>	<b>25,962,754.91</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>26,653,140.60</b>	<b>25,962,754.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	26,653,140.60	25,962,754.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	26,653,140.60	25,962,754.91
51210	Өмнөх үеийн үр дүн	26,653,140.60	26,653,140.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	(690,385.69)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>26,653,140.60</b>	<b>25,962,754.91</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>164,846,582.00</b>	<b>189,908,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,940,393.00</b>	<b>7,661,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,940,393.00	7,661,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,940,393.00	7,661,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,940,393.00	7,661,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>156,906,189.00</b>	<b>182,247,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,848,000.00	2,763,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,848,000.00	2,763,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	147,937,000.00	179,484,200.00



Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,937,000.00	179,484,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	121,189.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	121,189.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>161,730,003.49</b>	<b>190,598,585.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>161,730,003.49</b>	<b>190,598,585.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	151,192,906.55	171,422,348.20
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	105,716,123.19	124,995,995.72
210101	Үндсэн цалин	80,315,556.19	89,672,701.01
210102	Нэмэгдэл	20,228,513.00	30,873,294.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,172,054.00	4,450,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,198,338.00	16,663,739.46
210201	Тэтгэврийн даатгал	8,837,738.38	11,145,539.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,090,200.00	1,379,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	872,099.62	1,103,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	218,000.00	275,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,180,300.00	2,759,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,461,789.69	4,579,320.54
210301	Гэрэл, цахилгаан	763,751.00	721,709.14
210302	Түлш, халаалт	1,190,050.00	1,528,223.40
210303	Цэвэр, бохир ус	807,988.69	529,388.00
210304	Байрны түрээс	1,700,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,308,445.18	10,253,975.79
210401	Бичиг хэрэг	2,324,255.00	1,715,915.00
210402	Тээвэр, шатахуун	2,908,193.00	4,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,133,347.18	2,163,060.79
210404	Ном, хэвлэл	1,667,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,275,650.00	200,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,925,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,868,000.00	1,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	315,000.00	-
210604	Урсгал засвар	1,553,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,718,000.00	1,166,600.00
210702	Дотоод албан томилолт	2,718,000.00	1,166,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,714,600.00	3,378,831.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,976,500.00	2,615,331.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,207,610.49	8,883,885.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	682,500.00	631,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,525,110.49	8,252,885.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,537,096.94	19,176,237.49
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,847,600.00	2,007,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,847,600.00	2,007,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,689,496.94	-



213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,689,496.94	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	17,169,237.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,169,237.49
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,116,578.51</b>	<b>(690,385.69)</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	6,620,000.19	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,620,000.19	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(6,620,000.19)	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(3,503,421.68)</b>	<b>(690,385.69)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>159,042,029.00</b>	<b>184,145,200.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>159,042,029.00</b>	<b>184,145,200.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,848,000.00	4,661,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,848,000.00	4,661,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	147,937,000.00	179,484,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,937,000.00	179,484,200.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	2,257,029.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,257,029.00	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>154,203,729.00</b>	<b>183,376,500.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>154,203,729.00</b>	<b>183,376,500.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>141,409,603.06</b>	<b>162,302,262.51</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	105,716,123.19	124,995,995.72
210101	Үндсэн цалин	80,315,556.19	89,672,701.01
210102	Нэмэгдэл	20,228,513.00	30,873,294.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,172,054.00	4,450,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,198,338.00	16,663,739.46
210201	Тэтгэврийн даатгал	8,837,738.38	11,145,539.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,090,200.00	1,379,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	872,099.62	1,103,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	218,000.00	275,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,180,300.00	2,759,100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,461,789.69	4,579,320.54





Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	763,751.00	721,709.14
210302	Түлш, халаалт	1,190,050.00	1,528,223.40
210303	Цэвэр, бохир ус	807,988.69	529,388.00
210304	Байрны түрээс	1,700,000.00	1,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,733,252.18</b>	<b>8,181,975.79</b>
210401	Бичиг хэрэг	2,539,755.00	1,623,915.00
210402	Тээвэр, шатахуун	2,817,500.00	4,195,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,133,347.18	2,163,060.79
210404	Ном, хэвлэл	1,667,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	575,650.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,185,000.00</b>	<b>1,709,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	315,000.00	209,800.00
210604	Урсгал засвар	1,870,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,718,000.00</b>	<b>1,166,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,718,000.00	1,166,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,714,600.00</b>	<b>4,373,831.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,976,500.00	3,610,331.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>682,500.00</b>	<b>631,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	682,500.00	631,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,794,125.94</b>	<b>21,074,237.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,104,629.00</b>	<b>2,007,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,257,029.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,847,600.00	2,007,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,689,496.94</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,689,496.94	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>17,169,237.49</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,169,237.49



2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,898,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,898,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,838,300.00</u>	<u>768,700.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,523,500.00	768,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,023,500.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,023,500.00	2,212,500.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	30,277,751.28	30,277,751.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>30,277,751.28</b>	30,277,751.28
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,624,610.68)	(3,624,610.68)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<b>26,653,140.60</b>	26,653,140.60
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	<b>26,653,140.60</b>	26,653,140.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>26,653,140.60</b>	26,653,140.60
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(690,385.69)	(690,385.69)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<b>25,962,754.91</b>	25,962,754.91



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	153,829,032.06	179,484,200.00	162,314,962.51
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	150,514,232.06	179,484,200.00	162,314,962.51
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	141,409,603.06	178,234,200.00	161,907,962.51
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	105,716,123.19	137,956,200.00	124,995,995.72
210101	Үндсэн цалин	80,315,556.19	92,705,100.00	89,672,701.01
210102	Нэмэгдэл	20,228,513.00	39,581,100.00	30,873,294.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,172,054.00	5,670,000.00	4,450,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,198,338.00	17,244,500.00	16,663,739.46
210201	Тэтгэврийн даатгал	8,837,738.38	11,726,300.00	11,145,539.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,090,200.00	1,379,600.00	1,379,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	872,099.62	1,103,600.00	1,103,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	218,000.00	275,900.00	275,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,180,300.00	2,759,100.00	2,759,100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,461,789.69	5,122,500.00	4,579,320.54
210301	Гэрэл, цахилгаан	763,751.00	946,800.00	721,709.14
210302	Түлш, халаалт	1,190,050.00	1,549,500.00	1,528,223.40
210303	Цэвэр, бохир ус	807,988.69	826,200.00	529,388.00
210304	Байрны түрээс	1,700,000.00	1,800,000.00	1,800,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,733,252.18	8,499,800.00	8,018,975.79
210401	Бичиг хэрэг	2,539,755.00	1,462,200.00	1,460,915.00
210402	Тээвэр, шатахуун	2,817,500.00	4,197,200.00	4,195,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,133,347.18	2,640,400.00	2,163,060.79
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	575,650.00	200,000.00	200,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,185,000.00	4,300,000.00	4,289,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	315,000.00	2,500,000.00	2,489,500.00
210602	Тавилга	-	300,000.00	300,000.00



Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,870,000.00	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,718,000.00	2,480,200.00	1,166,600.00
210702	Дотоод албан томилолт	2,718,000.00	2,480,200.00	1,166,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,714,600.00	1,931,000.00	1,562,831.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,976,500.00	900,000.00	799,331.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	540,000.00	290,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	60,000.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,100.00	59,000.00	42,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	350,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	682,500.00	700,000.00	631,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	682,500.00	700,000.00	631,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,104,629.00	1,250,000.00	407,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,104,629.00	1,250,000.00	407,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,847,600.00	1,250,000.00	407,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	150,194,029.00	179,484,200.00	162,314,962.51
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	147,937,000.00	179,484,200.00	162,314,962.51
132001	Орон нутгийн төсвөөс	147,937,000.00	179,484,200.00	162,314,962.51
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	-	9.00	9.00
620001	Удирдах ажилтан	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	8.00	8.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-	<b>9.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	-	-	6.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	3.00



### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын дарга Д.Сайзмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 09-ноос 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь “Аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд системтэй, оновчтой арга хандлагаар санхүүгийн хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлэх замаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хараат бус бодитой дүгнэлт гарган аймгийн удирдлагын засаглалын эрсдэлийг бууруулах, хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бий болгох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, байгууллагын хөрөнгө, санхүүгийн бааз суурийг бэхжүүлэх, удирдлага зохион байгуулалтын үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, тусгай сангийн үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд эрсдэлд суурилсан дотоод аудит гүйцэтгэн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөтэй зарцуулах талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах;



- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн тусгай зориулалтын сангууд, төсөл хөтөлбөр, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэнд санхүүгийн хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалд хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;
- Албан хаагчдын мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулах тасралтгүй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэн мэргэшсэн аудитор, улсын байцаагч бий болох;
- Санхүүгийн хяналт, аудитын дотоод үйл ажиллагаанд чанарын баталгаажуулалт хийх, төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтан нарыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд тус байгууллагын нягтлан бодогч Ж.Энхзаяагийн өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн албаны даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн Б/06 тоот тушаалаар албан ажлаас чөлөөлж, 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн Б/07 тоот тушаалаар С.Цэрмааг нягтлан бодогчоор томилсон байна.

### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны хагас жилээр хийсэн дотоод хяналт шалгалтаар доорх зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- 1-4 сарын цалингийн бодолтонд ХХОАТатварын 18.4 мянган төгрөгийн зөрүү байгааг залруулах зөвлөгөө өгч ажилласан ба 10 сарын цалин дээр цалингийн зөрүүг арилгасан байна.
- 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 02 тоот СХААлбаны өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэлд актлах бараа материалын дүнг зөрүүтэй тусгасныг нягтлан бодогчид хэлж залруулсан байна.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 92,118.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 921.18 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 189,908.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,899.08 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 690.39 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,023.5	2,212.5	(1,811.0)
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	4,013.57	3,361.37	(652.2)
Үндсэн хөрөнгө	18,616.07	20,388.88	1,772.81
<b>Нийт хөрөнгө</b>	<b>26,653.14</b>	<b>25,962.75</b>	<b>(690.39)</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	26,653.14	25,962.75	(690,39)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>26,653.14</b>	<b>25,962.75</b>	<b>(690.39)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,212.5 мянган төгрөг болж 1,811.0 мянган төгрөгөөр буурсан нь цагаан сарын баярыг угтан 4 ахмадад тусламж үзүүлснээс шалтгаалжээ. Энэ нь ахмадын сангийн дансны хуулганы үлдэгдлээр баталгаажиг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,361.37 мянган төгрөг болж 652.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд худалдан авалтаар 9,884.7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, зарцуулалтаар 8,826.91 мянган төгрөгийн бараа материал буурч, байгууллагын даргын 2020 оны 07-р сарын 09-ны өдрийн А/24 тушаалыг үндэслэн 1,925.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20,388.88 мянган төгрөг болж 1,772.81 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2020 оны 06-р сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 1,740.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2020 оны 07-р сарын 17-ны өдрийн А/26 дугаар тушаалаар 6,006.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 2020 оны 11-р сарын 30-ны өдрийн А/40 дугаар тушаалаар 1,749.8 мянган төгрөгийн компьютерын дэлгэц, процессор, 2020 оны 12-р сарын 10-ны өдрийн А/42 дугаар тушаалаар 529.9 мянган төгрөгийн принтерийг орлогдож авснаас шалтгаалжээ.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 25,962.75 мянган төгрөг болж 690.39 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 25,181.8 мянган төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой.

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,940.39	7,661.0	(279.39)
Нэмэлт санхүүжилтийн орлого	8,848.0	2,763.0	(6,085.0)
Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,937.0	179,484.2	31,547.2
<b>Нийт дүн</b>	<b>164,726.4</b>	<b>189,908.20</b>	<b>25,181.8</b>

Нийт зардал өмнөх оноос 20,229.4 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал өссөн байна.

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	105,716.12	124,995.99	19,279.87
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,198.34	16,663.74	3,465.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,461.79	4,579.32	117.53
Хангамж, бараа материалын зардал	11,308.44	10,253.97	(1,054.47 )
Эд хогшил, урсгал засварын зардал	1,868.0	1,500.0	( 368.0 )
Томилолт, зочны зардал	2,718.0	1,166.6	(1,551.4 )
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,714.6	3,378.83	664.23
Бараа үйлчилгээний бусад зардал	9,207.61	8,883.88	(323.73 )
<b>Нийт дүн</b>	<b>151,192.9</b>	<b>171,422.3</b>	<b>20,229.4</b>

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 179,484.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 162,314.9 мянган төгрөг буюу 90.43 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд 19,067.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь Аймгийн дотоод аудитын хорооны үйл ажиллагаанд зориулж Засаг даргын нөөц сангаас 4,661.0 мянган төгрөгийн санхүүжилт





авч төрийн сангаас зарцуулах эрх нээлгэн зориулалтын дагуу 2,763.0 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 1,898.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Байгууллагын ахмадын сангийн данс оны эхэнд 4,023.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Монгол Улсын Ахмад настны тухай хуулийн холбогдох заалт, хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг үндэслэн байгууллагын даргын гаргасан 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/06 тоот тушаал, 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/29 тоот тушаал, 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/34 тоот тушаал, 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/35 тоот тушаалуудаар ахмадууддаа 1,811.0 мянган төгрөгийн тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгийг олгож, оны эцэст 2,212.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 5 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл байна. Тайлант онд нийт 3 удаагийн 4,200.0 мянган төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн зөрчилтэй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2019 оны санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 110 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна. Үүнд:

Аудитын зөвлөмж	Биелэлт
“Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17-р зүйлийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх, нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах.	2020 оны 2 сарын Нийгмийн даатгалын тайланд байцаагч Ц.Тэгшжаргалын дутуу тайлагнасан 110623 төгрөгийн цалинг нэмж тайлагнасан. Цаашид анхаарч ажиллах болно.
Албан шаардлага	Биелэлт
Тайлангийн хугацаанд 122.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг анхан шатны баримтгүйгээр /е баримтгүй/ худалдан авсан байна.	2019 оны 06 сарын 10 ний бичиг хэргийн материалд нийлүүлэлт хийсэн “Маамуу электроникс” ХХК е- баримт шивээгүй байсан. Оны эцсийн тооцоо нийлсэн актаар тухайн байгууллагаас 122.0 төгрөгийн бичиг хэргийн материал худалдаж авсан нь үнэн бараа материалыг орлогод авч шаардахаар зарцуулсан нь үнэн. Цаашид е-баримтыг тогтмол авч хэвшсэн.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,394.02 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,898.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 269.72 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 4,226.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.



## **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтээс төвлөрүүлэх 1,898.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаар бүртгэснийг залруулсан.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. 2020 оны 10-р сарын 01-ны өдрийн Б/7 дугаар тушаалаар тус байгууллагын нягтлан бодогч солигдож, шинээр томилогдсон ба 2020 оны 11 сард тус ажилтанд чанарын удирдлагын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд чанарын удирдлагын гишүүдэд урамшуулал олгох гэсэн тушаалаар ажилд оролцсон оролцоо, ямар үүрэгтэй оролцож ямар үр дүнг гаргасанг тодорхойлолгүй үндсэн цалингийн 40%-тай тэнцэх 269.72 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Засгийн газрын 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна". Мөн 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 4,226.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны ажилчдын цалин дээр олгож буй нэмэгдэл урамшууллыг ямар үндэслэлээр олгож буйг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1.Зардлын данстай холбоотой асуудал**

1. Илрүүлэлт: Ахлах мэргэжилтний 143.4 мянган төгрөгийн ажил олгогчоос олгох ХЧТАТэтгэмжээс нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татвар суутгаж тооцон 26.3 мянган төгрөгийг дутуу олгосон байна.
2. Эрсдэл: Цалин хөлстэй холбоотой хууль, тогтоол, журам заавар зөрчсөн байх.



Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29.4-т "Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно" гэсэн заалтын дагуу ажил олгогчоос олгох 5 хоногийн ХЧТАТ тэтгэмжээс суутгал тооцохгүй байх.
4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 64 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

**2. Шилэн данстай холбоотой асуудал**

1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан 5 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл буюу 4,200.0 мянган төгрөгийн тушаалыг мэдээллээгүй байсныг залруулж оруулсан байна.
2. Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн ил тод байдал алдагдах, хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах.
3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1. 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 64 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Бэлтгэсэн:

Аудитор

Б.Пүрэвсүрэн

Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер



Б.Эрдэнэ

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах

Огноо